



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын “Ердийн даатгалын компанийн даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийн орлого, даатгуулагчийн тоо” гэсэн 7, “Ердийн даатгалын компанийн нөхөн төлбөр, нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо” гэсэн 8, “Ердийн даатгалын компанийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” гэсэн 11, “Ердийн даатгалын компанийн учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” гэсэн 12, “Ердийн даатгалын компанийн нэхэмжилсэн хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” гэсэн 13, “Ердийн даатгалын компанийн учирч болзошгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайлан” гэсэн 14, “Давхар даатгалын компанийн дэлгэрэнгүй мэдээллийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан” гэсэн 24, “Даатгалын зуучлагч компанийн зуучилсан даатгалын үнэлгээ, зуучилсан даатгалын хураамж, зуучлалын орлого” гэсэн 27, “Даатгалын хохирол үнэлэгч компанийн хохирол үнэлгээний тоо, үнэлсэн хохирлын хэмжээ, үнэлгээний орлого” гэсэн 29 дүгээр хавсралтуудад дор дурьдсан агуулгатай 1.13, 1.14, 1.15, 1.16, 1.17 дугаар мөр бүхий даатгалын хэлбэрийг тус тус нэмсүгэй:

1/ “1.13. Зээлийн даатгал”,

2/ “1.14. Итгэлцлийн даатгал”,

001342

3/ “1.15. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал”,

4/ “1.16. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал”,

5/ “1.17. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал”.

2. Журамд нэмэлтийг оруулж даатгагчдад мэдэгдэж ажиллахыг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН